



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 33 (170)

**Монгол Улсын Хууль:**

- *Конвенци соёрхон батлах тухай*

**Монгол Улсын Их Хурлын Тогтоол:**

- *Ерөнхийлөгчийн хоригийн тухай*
- *Монгол Улсын 1999 оны улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**

**Улаанбаатар хот  
2000 он**



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны есдүгээр сарын 5

№33 (170)

## Гарчиг

### Нэр. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

349. Конвенци соёрхон батлах тухай (2000-8-31-ний хууль) 624

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

350. Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг нөхөн томилох тухай Дугаар 18 624
351. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай Дугаар 19 624
352. Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 20 624
353. Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох тухай Дугаар 21 625
354. Төрийн захиргааны албаны зөвлөлийн даргыг нөхөн томилох тухай Дугаар 22 625
355. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Дугаар 23 625
356. Монгол Улсын 1999 оны улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Дугаар 24 625
357. Монгол Улсын Ерөнхий сайд асан Р.Амаржаргалын хамгаалалт, хангамжийн тухай Дугаар 25 626
358. Монголбанкны Тэргүүн Дэд ерөнхийлөгчийг томилох тухай Дугаар 26 626

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

359. Аюушийн Зумаад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 126 627
360. Бадарын Варнишкад Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай Дугаар 127 627
361. Самбуугийн Бооройд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 128 627
362. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 129 627
363. Чимэдцэрэнгийн Долгорсүрэнг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 130 630
364. Энхбаатарын Тэгшжаргал, Гомбодэлгэрийн Эрдэнэбулган нарыг "Шударга журам" медалиар нэхэн шагнах тухай Дугаар 131 630
365. Зарим ахмад дайчныг одонгоор шагнах тухай Дугаар 132 630
366. Зарим багш нарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 133 632
367. Дамбийн Оюунцэцэгт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 134 633

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

368. "Өршөөл үзүүлэх тухай" Монгол Улсын хуулийн зарим заалтыг хэрэглэх тухай Дугаар 244 633
369. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Дугаар 303 634

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 8 дугаар  
сарын 31-ний өдөр

Улаанбаатар  
хот

### Конвенци соёрхон батлах тухай

1 дүгээр зүйл. Алан хядах зорилгоор бөмбөг хэрэглэхтэй тэмцэх тухай олон улсын Конвенцийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2000 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар  
хот

### Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг нөхөн томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас дэвшүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр нөхөн томилсугай.

2. Энэ тогтоолыг 2000 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Жамбын Норовсамбууг Төрийн

ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар  
хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Монголбанкны үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас хийсэн шалгалтын дүнг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2. Монголбанкны 1997-2000 оны санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж, дүнг 2000 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Төрийн хаан шалгах хороо /Л.Жавзмаа/-нд даалгасугай.

1. Банкны тухай хууль тогтоомж, Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх явцад Монголбанкны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийн явцыг Улсын Их Хуралд илтгэхийг Монголбанкны Ерөнхийлөгч (О.Чулуунбат)-д даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Т.Очирхүү/-нд даалгасугай.

ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар  
хот

### Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2000 оны 8 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Жигжидийн Үнэнбатыг үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн гэж үзэж Монголбанкны

ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монголбанкны Ерөнхийлөгчөөр Очирбатын Чулуунбатыг томилсугай.

2.О.Чулуунбатыг

Монголбанкны

**Монголбанкны Ерөнхийлөгчийг  
томилох тухай**

Ерөнхийлөгчөөр томилогдсонтой холбогдуулан түүнийг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2000 оны 8 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ДЭД ДАРГА**

**Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 22

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 7, 12 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдаас Ерөнхийлөгчтэй зөвшилцөн санал болгосныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Жамбын Норовсамбууг Монгол Улсын

**Төрийн захиргааны албаны зөвлөлийн  
даргыг нөхөн томилох тухай**

Төрийн захиргааны албаны зөвлөлийн даргаар нөхөн томилсугай.

2.Энэ тогтоолыг 2000 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ДЭД ДАРГА**

**Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 23

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын 2000 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн

**Ерөнхийлөгчийн хоригийн тухай**

сайд"-ын эрхлэх ажлын үндсэн хүрээнээс "улсын хил хамгаалалтын асуудал" гэснийг хасаж, улсын хилийг хамгаалах асуудлыг Батлан хамгаалахын сайдын эрхлэх ажлын хүрээнд хэвээр нь үлдээхээр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн авах боломжгүй гэж үзсүгэй.

**ДЭД ДАРГА**

**Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 24

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 1999 оны улсын

**Монгол Улсын 1999 оны улсын  
төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг  
батлах тухай**

төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн орлогыг 215.116.707.8 мянган төгрөгөөр, зарлагыг 316.173.626.5 мянган төгрөгөөр баталсугай.

2.Монгол Улсын 1999 оны улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг баталсантай





холбогдуулж дараахь арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/ 1999 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлд иж бүрэн дүн шинжилгээ хийж, төсвийн орлого зарлагын гүйцэтгэлийг тооцох нэгдсэн аргачлалыг боловсронгуй болгох;

2/ 2001 оны төвлөрсөн төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ аймаг, нийслэл, сум, дүүрэг, төсөвт байгууллагын урьд жилүүдийн он дамжин хуримтлагдсан өрийг нэг мөр шийдвэрлэх тодорхой санал боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах;

3/ олон объектод нэг зэрэг хөрөнгө оруулалт хийж улсын дүнгээр дуусаагүй барилгын хэмжээг нэмэгдүүлэн, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байгаа дутагдлыг арилгах арга хэмжээ авах;

4/ эрчим хүчний системийн байгууллагын өр, авлагыг шийдвэрлэх тодорхой саналыг боловсруулж Улсын Их Хуралд энэ оны 12 дугаар сарын 1-ний дотор танилцуулах.

5/ төсвийн хууль тогтоомжийг биелүүлэхгүй санхүүгийн сахилгыг удаа дараа зөрчиж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, бүх шатны төсөв захирагчид зохих хууль тогтоомжийн дагуу тухай бүр хариуцлага тооцож байх;

6/ гадаадын зээл тусламжийн тухай хуулийн төсөл боловсруулж энэ онд багтааж Улсын Их Хуралд өргөн барих.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Н.Баяртсайхан/-нд даалгасугай.

**ДЭД ДАРГА**

**Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

### Монгол Улсын Ерөнхий сайд асан Р.Амаржаргалын хамгаалалт, хангамжийн тухай

Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайдын алба хашиж байсан Р.Амаржаргалыг нэгэн бүрэн эрхийн хугацаанд хамгаалах ажлыг Төрийн тусгай хамгаалалтын газарт хариуцуулсугай.

2.Засгийн газар /Н.Энхбаяр/-т дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

1/ энэхүү тогтоолын 1-д заасан хугацаанд Р.Амаржаргалд Засгийн гзараас

тогтоосон журмын дагуу суудлын автомашинаар үйлчлэх;

2/ Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан Р.Амаржаргалд Улсын Их Хурлын 2000 оны 10 дугаар тогтоолоор тогтоосон цалин, бусад нэмэгдэлтэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг 6 сарын хугацаанд олгох;

3/ энэ тогтоолын 2 дахь хэсгийн 2-т заасан хугацааны дотор ажил, албан тушаал эрхэлбэл томилогдсон ажил, албан тушаалын цалин хөлс нь өмнөх албан тушаалынхаас бага байвал зөрүүг тооцож олгох.

**ДЭДДАРГА**

**Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

### Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

дэд ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2000 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1.Алагийн Батсүхийг Монголбанкны Тэргүүн

**ДЭДДАРГА**

**Ж.БЯМБАДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

**Аюушийн Зумаад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Хөнгөн үйлдвэрийн салбарт үр бүтээлтэй ажиллаж, нэхмэл сүлжмэлийн үйлдвэрүүдийн үйлдвэрлэл, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, чанарыг дээшлүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд олон жилийн турш оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж нийслэлийн

"Сүлжээ" хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Аюушийн Зумаад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

**Бадарын Варнишкад Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай**

Авто замын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, замын далан, суурь, хучилт, засал чимэглэлийн ажлыг улирал, цаг агаарын онцлогт тохируулан чадварлаг гүйцэтгэж, замын сүлжээг хөгжүүлэх, залуу ажилчдыг сургаж хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж зам барилга, арчлалтын "Эрдэнэ зам" төрийн

өмчит үйлдвэрийн газрын автогрейдерчин Бадарын Варнишкад Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

**Самбуугийн Бооройд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай**

Урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж монгол, казах ардын болон зохиолын олон арван дууг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг дуулж, үзэгчид сонсогчдын талархал хүлээж, нийтийн дууны урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын ахмадын холбооны дэргэдэх ахмад уран

бүтээлчдийн "Алтан үе" чуулгын гоцлол дуучин Самбуугийн Бооройд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир спорт, прокурор, банк, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил

амжилт гарган ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- |                           |  |
|---------------------------|--|
| 1. Товуугийн Насанбуян    | - Улсын ардын дуу бүжгийн чуулгын фондын эрхлэгч, арга зүйч                |
| 2. Тэгшжаргалын Сэнгэдорж | - Монгол улсын их сургуулийн Хууль зүйн дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч   |
| 3. Сэнгэдоржийн Төмөрбат  | - Улаанбаатар хотын зорчигч тээврийн "Автобус-2" компани /УУГ/-ийн захирал |

4. Далхайн Хөхөө	- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн хүүхдийн зөвлөх эмч
<b>"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:</b>	
1. Ёндонжамцын Адъяадорж	- Дундговь аймгийн Луус сумын өндөр настан
2. Моломын Алтангэрэл	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт
3. Шагдарын Алтанцэцэг	- Нийслэлийн хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн "Хүнс тех" корпорацийн эрдэм шинжилгээний ажилтан
4. Чадраабалын Аюуш	- Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын их эмч
5. Цэрэндоржийн Бадиа	- Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга
6. Жамъянсүрэнгийн Балсанлхүндэв	- Тээврийн прокурорын орлогч
7. Төгөөгийн Батбаяр	- Москва хот дахь Олон улсын хөрөнгө оруулалтын банкны эдийн засгийн газрын орлогч дарга
8. Цэрэнгийн Батнасан	- Нийслэлийн үйлдвэрлэл үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
9. Гонгоржавын Батхүрэл	- Нийслэлийн худалдаа үйлчилгээний "БСБТ" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч
10. Шаравын Биндэрьяа	- Нийслэлийн худалдаа үйлчилгээний "Аяны тэнгэр" ХХК-ийн жолооч
11. Авирмэдийн Бузмаа	- Эрүүл мэндийн яамны ахлах мэргэжилтэн
12. Цээнгийн Бямбаа	- Дундговь аймгийн Мандалговь сумын "Говийн төгөл" ХХК-ийн захирал
13. Дашийн Ганбаатар	- Нийслэлийн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн электрон техник, машин судлалын нэгдлийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан
14. Пэрэнлэйн Гантөмөр	- Эрүүл мэндийн ажилтны Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга
15. Чимидийн Гансүх	- Үндэсний татварын ерөнхий газрын татварын улсын байцаагч
16. Намдагийн Даваадорж	- Булган аймгийн Дашинчилэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга
17. Рэгнээгийн Дагвадорж	- Говь-Алтай аймгийн "Ус-Алтай" ХК-ийн захирал
18. Дашболхойн Дамбадаржаа	- Монголын радио телевизийн Хэрэг эрхлэх газрын үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
19. Лодойн Дансранхүү	- Төр, засгийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх газрын барилгын ангийн инженер
20. Шаравын Долгормаа	- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн 5 дугаар төвийн ерөнхий эмч
21. Лувсанбалдангийн Доржпүрэв	- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын жолооч
22. Сүхийн Дэлгэр	- Дархан-Уул аймгийн Дулааны шугам сүлжээний газрын дарга
23. Дамдинсүрэнгийн Ёндон	- Үндэсний татварын ерөнхий газрын татварын улсын ахлах байцаагч
24. Баасангийн Жияандорж	- Монголын спорт, аяллын холбооны дарга
25. Баярын Зориг	- Нийслэлийн худалдаа, үйлдвэрийн "Материалимпекс" ХК-ийн ерөнхий захирал
26. Мөнхбаярын Коля	- Дорнод аймгийн Чойбалсан хотын тохижилт, үйлчилгээний албаны жолооч
27. Сэрээтэрийн Лхүндэв	- Арьсны өвчин судлалын төвийн зөвлөх эмч
28. Нансалын Мөнхөө	- Булган аймгийн биеийн тамир, спортын төвийн дасгалжуулагч
29. Доржсүрэнгийн Найдан	- Нийслэлийн Өмчийн газрын орлогч дарга
30. Очирбатын Найдансод	- Төв аймгийн Бүрэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга
31. Баяртогтохын Намжилмаа	- Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Өгөөж-чихэр боов" ХХК-ийн нягтлан бодогч
32. Дагдангийн Намсрай	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга
33. Лувсандамбын Нарангэрэл	- Нийслэлийн Налайх дүүргийн Боловсрол, соёлын төвийн дэд захирал
34. Хандын Наранхүү	- Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд захирал, нислэгийн аюулгүй байдал, зохицуулалтын албаны дарга



- |                               |  |
|-------------------------------|--|
| 35. Осорын Насанбат           | - Удирдлагын академийн сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал                                       |
| 36. Балжиннямын Нормжинлхам   | - Үндэсний татварын ерөнхий газрын татварын улсын ахлах байцаагч   |
| 37. Намбарын Нямдорж          | - Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын барилгын ахлах даамал                                     |
| 38. Гэгэдийн Оюунгэрэл        | - Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн сувилагч   |
| 39. Жамбалын Өлзийбуян        | - Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын байгаль хамгаалагч   |
| 40. Ендонгийн Өлзийхутаг      | - Монголын урчуудын эвлэлийн хорооны зураач  |
| 41. Чойсүрэнгийн Содномдаржаа | - Эрчим хүчний удирдах газрын харъяа Налайхын дулааны станцын инженер                                      |
| 42. Санзаагийн Сонинтөр       | - Ховд аймгийн Мөнххайрхан сумын өндөр настан  |
| 43. Жамбалдоржийн Сэржээ      | - Улсын төв номын сангийн захирал  |
| 44. Ономын Сэрэээн            | - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн өндөр настан, ахмад зохиолч   |
| 45. Лэгдэнгийн Сэсээр         | - Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэлийн "Материалимпекс" ХК-ийн жолооч  |
| 46. Чойжилын Тулгач           | - Дорнод аймгийн худалдаа үйлдвэрлэлийн "Адуунчулуун" ХК-ийн өндөр хүчдэлийн цахилгаанчин                  |
| 47. Балдандоржийн Туяа        | - Монголын хошин урлагийн театрын жүжигчин   |
| 48. Лувсангийн Түдэв          | - Нийслэлийн зорчигч тээврийн "Морин эрдэнэ трейд" ХХК-ийн захирал   |
| 49. Доржлаламын Паймий        | - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын зам засвар, арчлалтын "Талын зам" ХХК-ийн жолооч                      |
| 50. Ядамжавын Пүрэвэ          | - Үндэсний татварын ерөнхий газрын бодлого, аргачлалын хэлтсийн дарга                                      |
| 51. Гиваажавын Пүрэвдорж      | - Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ гурил тэжээл" ХК-ийн дэд захирал  |
| 52. Төгсийн Пүрэвдорж         | - Нийслэлийн худалдаа, зуучлалын "Хүрээт" ХХК-ийн захирал  |
| 53. Санзайн Төмөртоого        | - Дорнод аймгийн дулааны цахилгаан станцын токарьчин   |
| 54. Балдангийн Халтар         | - Дундговь аймгийн архивын тасгийн фондчин   |
| 55. Чилхаагийн Хархүү         | - Ховд аймгийн Мест сумын соёлын төвийн захирал  |
| 56. Содномын Хоньхүү          | - Дархан-Уул сумын Дулааны шугам сүлжээний газрын слесарьч   |
| 57. Сандагийн Хүрэлбаатар     | - Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд захирал  |
| 58. Сүрэнхүүгийн Циенхорлоо   | - Нийслэлийн хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн "Хүнс тех" корпорацийн ахлах инженер                   |
| 59. Дамдингийн Цэндээ         | - Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны эрдэм шинжилгээ, сургалтын төвийн захирал                      |
| 60. Өөдөөгийн Цэрэндорж       | - Үнэт цаасны хорооны мэдээлэл, дотоод ажлын тасгийн дарга   |
| 61. Доржсүрэнгийн Чилхаа      | - Дорнод аймгийн дулааны цахилгаан станцын инженер   |
| 62. Цоодолын Чимэддулам       | - Нийслэлийн хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн "Хүнстех" корпорацийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан |
| 63. Цэдэнсамбын Шаалайхүү     | - Монголын тахир, дутуу иргэдийн төв зөвлөлийн зураач  |
| 64. Шархүүгийн Шажинбат       | - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Авто тээврийн газрын мэргэжилтэн                                    |
| 65. Алтангэрэлийн Шаравсамбуу | - Архангай аймгийн Хянан шалгах хорооны дарга  |

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- |                              |  |
|------------------------------|--|
| 1. Нацагнамын Болд           | - Булган аймгийн Булган сумын "Авто тээвэр-Булган" ХХК-ийн жолооч                                    |
| 2. Доржийн Гончигдаш         | - Дорнод аймгийн дулааны цахилгаан станцын эрчим хүчний борлуулалтын хяналтын байцаагч               |
| 3. Жамсрангийн Дашням        | - Дорнод аймгийн дулааны цахилгаан станцын металл судлал, гагнуурын мастер                           |
| 4. Дүгэржавын Досмаа         | - Улсын төв номын сангийн ерөнхий нягтлан бодогч   |
| 5. Түмэнгийн Жадамбаа        | - Өмнөговь аймгийн Прокурорын газрын туслах прокурор   |
| 6. Ганжууржавын Оюун         | - Нийслэлийн хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн "Хүнстех" корпорацийн эрдэм шинжилгээний ажилтан |
| 7. Намидын Тодбаатар         | - Өмнөговь аймгийн Номгон сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн мэргэжилтэн                |
| 8. Цэрэннадмидын Туяа        | - Нийслэлийн хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн "Хүнстех" корпорацийн ажилтан                    |
| 9. Цэндсүрэнгийн Хүрэлбор    | - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын зам засвар, арчлалтын "Талын зам" ХХК-ийн захирал               |
| 10. Буяагийн Цэгмид          | - Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн эрхлэгч, их эмч                                |
| 11. Цэвээндолгорын Цэдэндорж | - Үндэсний татварын ерөнхий газрын улсын бүртгэлийн албаны улсын байцаагч                            |
| 12. Чогсомын Эрдэнэбилэг     | - Нийслэлийн авто тээврийн "Тав" ХК-ийн жолооч   |





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

Чимэдцэрэнгийн Долгорсүрэнг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг, авхаалж самбаа гарган галын аюулаас хүүхдүүдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн тоосгоны үйлдвэрийн ажилчин Чимэдцэрэнгийн Долгорсүрэнг "Шударга

журам" медалиар шагнаасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Энхбаатарын Тэгшжаргал, Гомбодэлгэрийн Эрдэнэбулган нарыг "Шударга журам" медалиар нэхэн шагнах тухай

Эр зориг, хүнлэг ариун сэтгэл гарган тэмцэж усанд живсэн хүүхдийг авран өөрснөө амь эрсэдсэн Төв аймгийн Сүмбэр сумын дунд сургуулийн сурагч агсан Энхбаатарын Тэгшжаргал, Гомбодэлгэрийн Эрдэнэбулган нарыг "Шударга журам" медалиар

нэхэн шагнаасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 8 дугаар сарын 8-ний өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Зарим ахмад дайчныг одонгоор шагнах тухай

1945 оны чөлөөлөх дайнд биелчлэн оролцож, эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах үйлст оруулсан хувь нэмрийг нь үнэлж хавсралтад дурдсан ахмад дайчдыг одонгоор

шагнаасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

*Ерөнхийлөгчийн 2000 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 132 тоот зарлигийн хавсралт*

### ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Дамчаагийн Цэрэндаш - Дархан-Уул аймаг
2. Дэжидийн Бавуудорж - Дорноговь аймаг
3. Гарьдын Баатар - Дорнод аймаг
4. Луузангийн Гүнд - Төв аймаг
5. Маанийн Зинэмэдэр - Төв аймаг
6. Шаравжамцын Лхагва - Төв аймаг
7. Жамбалдагвын Дамдин - Хөвсгөл аймаг
8. Оригийн Баясгалан - Хэнтий аймаг
9. Жанлавын Нямдарь - Баянгол дүүрэг
10. Шонхорын Төмөрсүх - Баянгол дүүрэг
11. Пүрэвийн Дашжамц - Баянзүрх дүүрэг
12. Бигэрийн Хуваах - Баянзүрх дүүрэг
13. Зундуйн Бадам - Сонгинохайран дүүрэг

16. Жамбын Ранаажав - Сонгинохайран дүүрэг
17. Найдангийн Шагдар - Сонгинохайран дүүрэг
18. Сумъяагийн Базарваань - Сүхбаатар дүүрэг
19. Гүнтэвийн Гончоо - Сүхбаатар дүүрэг
20. Бүтэдийн Дашцэвэг - Сүхбаатар дүүрэг
21. Аюурын Жанчивдорж - Сүхбаатар дүүрэг
22. Балдирын Балдандорж - Хан-Уул дүүрэг
23. Рэнчимэдийн Батсүх - Хан-Уул дүүрэг
24. Хашийн Сэтэв - Хан-Уул дүүрэг
25. Гаасүрэнгийн Пүрэвжал - Чингэлтэй дүүрэг

### ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

14. Биньяагийн Лааган - Сонгинохайран дүүрэг
15. Дэмбээгийн Очир - Сонгинохайран дүүрэг

1. Балдангийн Бэгзжав - Архангай аймаг
2. Лувсандоржийн Гомбо - Архангай аймаг
3. Вандангийн Дамбадондог - Архангай аймаг

4. Дэндэвийн Дондогдорж	- Архангай аймаг	63. Цэрэндоржийн Бадамцэрэн	- Өмнөговь аймаг
5. Цэнджавын Жанцансамбуу	- Архангай аймаг	64. Охины Бадарч	- Өмнөговь аймаг
6. Галсангийн Иш	- Архангай аймаг	65. Содовын Дорж	- Өмнөговь аймаг
7. Лувсангийн Хандсүрэн	- Архангай аймаг	66. Дашийн Лувсандаш	- Өмнөговь аймаг
8. Чинзгийн Батхуяг	- Баян-Өлгий аймаг	67. Янжвийн Намдаг	- Өмнөговь аймаг
9. Дамдингийн Лэгчид	- Баян-Өлгий аймаг	68. Бөөнхүүгийн Хүү	- Өмнөговь аймаг
10. Мөндөнгийн Бямбасүрэн	- Баянхонгор аймаг	69. Наваанчүлтэмийн Ринчиндорж	- Сүхбаатар аймаг
11. Дашжамцын Доржням	- Баянхонгор аймаг	70. Отгоны Дамдинсүрэн	- Сэлэнгэ аймаг
12. Аюурын Жанцан	- Баянхонгор аймаг	71. Сандагийн Дашдондог	- Сэлэнгэ аймаг
13. Даваажавын Пүрэвсүрэн	- Баянхонгор аймаг	72. Янзмаагийн Нанжидлунсал	- Сэлэнгэ аймаг
14. Чойжавын Гомбо	- Булган аймаг	73. Содовын Самбуудорж	- Сэлэнгэ аймаг
15. Гомбын Дорж	- Булган аймаг	74. Дэмбэрэлийн Санжаа	- Сэлэнгэ аймаг
16. Дундаарийгийн Дэмбэрэл	- Булган аймаг	75. Наваантогтохын Бадамгарав	- Төв аймаг
17. Сономбалын Лханаажав	- Булган аймаг	76. Насанхүүгийн Батбилэг	- Төв аймаг
18. Очирын Намжилдорж	- Булган аймаг	77. Дэндэвийн Бэрээвэн	- Төв аймаг
19. Ядамдын Рагчаа	- Булган аймаг	78. Загдын Дагдансүрэн	- Төв аймаг
20. Балдангийн Сэрээтэр	- Булган аймаг	79. Рэнцэнгийн Дугар	- Төв аймаг
21. Лувсангийн Пунцаг	- Говь-Алтай аймаг	80. Чагнаагийн Лувсанжамъян	- Төв аймаг
22. Луудоржийн Аюур	- Говь-Алтай аймаг	81. Самацдын Лувсанцэнд	- Төв аймаг
23. Гэндэнгийн Дашцэрэн	- Говь-Алтай аймаг	82. Чагнаагийн Нороврэнцэн	- Төв аймаг
24. Ганжуурын Жамц	- Говь-Алтай аймаг	83. Дамзангийн Цэрэндаш	- Төв аймаг
25. Шаравын Самбуу	- Дархан-Уул аймаг	84. Гомбосүрэнгийн Чогсомжав	- Төв аймаг
26. Самбуугийн Гунгаа	- Дархан-Уул аймаг	85. Нямын Чүлтэмсүрэн	- Төв аймаг
27. Ядамын Наранбямба	- Дархан-Уул аймаг	86. Доржийн Шагдарсүрэн	- Төв аймаг
28. Довын Юмжав	- Дорноговь аймаг	87. Гэнэнгийн Дуглаа	- Увс аймаг
29. Лувсангийн Лувсаншарав	- Дорноговь аймаг	88. Санжмятавын Доржсүрэн	- Ховд аймаг
30. Цэрэнжавын Монхоодой	- Дорноговь аймаг	89. Шөмбөгийн Минжгээ	- Ховд аймаг
31. Цэвэгийн Хүрэл	- Дорнод аймаг	90. Хөхийн Норзон	- Хөвсгөл аймаг
32. Сандуйжавын Цэндоо	- Дорнод аймаг	91. Навааны Алтангэрэл	- Хөвсгөл аймаг
33. Равжаагийн Буурай	- Дорнод аймаг	92. Аюурааны Бадрах	- Хөвсгөл аймаг
34. Цэвээний Галсанжамц	- Дорнод аймаг	93. Жамбалын Даваадорж	- Хөвсгөл аймаг
35. Нүрэнгийн Гочоо	- Дорнод аймаг	94. Бүргэдийн Дандиахүү	- Хөвсгөл аймаг
36. Доржийн Дамдинжав	- Дорнод аймаг	95. Гиваадашийн Дорлигжав	- Хөвсгөл аймаг
37. Гомбын Дамдинсүрэн	- Дундговь аймаг	96. Аюушийн Лувсан-Ядам	- Хөвсгөл аймаг
38. Цэвээний Товуу	- Дундговь аймаг	97. Баатарын Сумъяажав	- Хөвсгөл аймаг
39. Бүрнээгийн Чанарав	- Дундговь аймаг	98. Гомбын Чимэддорж	- Хөвсгөл аймаг
40. Лувсанжавын Аюушжав	- Дундговь аймаг	99. Лааганы Шагдаррагчаа	- Хэнтий аймаг
41. Бадамын Гүндсамба	- Дундговь аймаг	100. Дашийн Даваажав	- Хэнтий аймаг
42. Даржаагийн Дамдиндорж	- Дундговь аймаг	101. Содномын Дамбийням	- Хэнтий аймаг
43. Амаржаргалын Дамдинжав	- Дундговь аймаг	102. Доржийн Дондог	- Хэнтий аймаг
44. Пагамын Дандар	- Завхан аймаг	103. Лхавааны Лувсанданзан	- Хэнтий аймаг
45. Уушийн Намбаа	- Завхан аймаг	104. Тогоочийн Лувсансүх	- Хэнтий аймаг
46. Гунгаасамбуугийн Гоодорго-Чойжавын Гэндэн	- Завхан аймаг	105. Норовын Наваанжанцан	- Хэнтий аймаг
48. Банзрагчийн Живаахүү	- Завхан аймаг	106. Дугаржавын Цэвээндорж	- Хэнтий аймаг
49. Бат-Өлзийн Сономдаш	- Завхан аймаг	107. Раднаагийн Жигжиджав	- Багануур дүүрэг
50. Жигжидийн Сүх-Очир	- Орхон аймаг	108. Пэлжээгийн Мажиг	- Багануур дүүрэг
51. Пүрэвийн Ядам	- Орхон аймаг	109. Цэрэнжавын Базар	- Баянгол дүүрэг
52. Дашийн Бат-Очир	- Орхон аймаг	110. Санжмятавын Данзан	- Баянгол дүүрэг
53. Цэрэнгийн Дамбаравжаа	- Өвөрхангай аймаг	111. Жадамбын Должин	- Баянгол дүүрэг
54. Рагчаагийн Дондогжамцан	- Өвөрхангай аймаг	112. Сэнгийн Должин	- Баянгол дүүрэг
55. Өсөхийн Халтар	- Өвөрхангай аймаг	113. Самдангийн Палам	- Баянгол дүүрэг
56. Нарангийн Банди	- Өвөрхангай аймаг	114. Сэнгийн Рэнцэндорж	- Баянгол дүүрэг
57. Эрмаагийн Гаваа	- Өвөрхангай аймаг	115. Гамаагийн Цэрэн	- Баянгол дүүрэг
58. Шийлээгийн Дагвадорж	- Өвөрхангай аймаг	116. Санжхүүгийн Чойжилжав	- Баянгол дүүрэг
59. Жигмэдийн Түдэв	- Өвөрхангай аймаг	117. Намгарын Вандан	- Баянзүрх дүүрэг
60. Чувганцын Хайдав	- Өвөрхангай аймаг	118. Рэнчиндаваагийн Данзаншагдар	- Баянзүрх дүүрэг
61. Осоржавын Цэрэнбат	- Өвөрхангай аймаг		
62. Жигмэдцэрэнгийн Чойгийдагва	- Өвөрхангай аймаг		



119. Хайдавын Дашдэндэв	- Баянзүрх дүүрэг	149. Балжирын Халзанхүү	- Хан-Уул дүүрэг
120. Вандуйн Лувсанжигмэд	- Баянзүрх дүүрэг	150. Цэрэнгийн Цэвээн	- Хан-Уул дүүрэг
121. Няндагийн Хоровжав	- Баянзүрх дүүрэг	151. Гаажидын Шантай	- Хан-Уул дүүрэг
122. Жамцын Чүлтэм	- Баянзүрх дүүрэг	152. Дэндэвийн Шарав	- Хан-Уул дүүрэг
123. Лхамжавын Чүлтэм	- Баянзүрх дүүрэг	153. Чимэдцэрэнгийн Балдан-Осор	- Чингэлтэй дүүрэг
124. Намсрайн Шаравдорж	- Баянзүрх дүүрэг	154. Тангаагийн Батбанди	- Чингэлтэй дүүрэг
125. Дашдэндэвийн Жигжидсүрэн	- Налайх дүүрэг	155. Нанзадын Гомбосүрэн	- Чингэлтэй дүүрэг
126. Очирын Түвшин	- Налайх дүүрэг	156. Сувдын Гончиг	- Чингэлтэй дүүрэг
127. Баасангийн Шагдар	- Налайх дүүрэг		
128. Дагдангийн Галсанпүрэв	- Сонгинохайрхан дүүрэг	157. Сүүлийн Дондог	- Чингэлтэй дүүрэг
129. Рэнчинжавын Дамбадаржаа	- Сонгинохайрхан дүүрэг	158. Нямдэлэгийн Ёндонжамц	- Чингэлтэй дүүрэг
130. Намсрайн Дамдинсүрэн	- Сонгинохайрхан дүүрэг	159. Аюушийн Мижид	- Чингэлтэй дүүрэг
131. Ламжавын Дондонхүү	- Сонгинохайрхан дүүрэг	160. Сономын Найдан	- Чингэлтэй дүүрэг
132. Долгорын Лувсанжав	- Сонгинохайрхан дүүрэг	161. Раднаагийн Равжаа	- Чингэлтэй дүүрэг
133. Гончигийн Тавхай	- Сонгинохайрхан дүүрэг	162. Доржийн Сандмаа	- Чингэлтэй дүүрэг
134. Гүржавын Чүлтэм	- Сонгинохайрхан дүүрэг	163. Гэндэнгийн Төмөрбаатар	- Чингэлтэй дүүрэг
135. Балбарын Дарамбазар	- Сонгинохайрхан дүүрэг	164. Нүрдийн Хаст	- Чингэлтэй дүүрэг
136. Дашбалбарын Гярдгаа	- Сүхбаатар дүүрэг	165. Самбуугийн Шарав	- Чингэлтэй дүүрэг
137. Бямбажавын Долгорсүрэн	- Сүхбаатар дүүрэг		
138. Мөнхийн Дугарсүрэн	- Сүхбаатар дүүрэг		
139. Дуламын Наран	- Сүхбаатар дүүрэг		
140. Балдандоржийн Нямбуу	- Сүхбаатар дүүрэг		
141. Долгорын Равдан	- Сүхбаатар дүүрэг		
142. Сэрээтэрийн Халзхүү	- Сүхбаатар дүүрэг		
143. Бат-Очирын Цэндээхүү	- Сүхбаатар дүүрэг		
144. Цэгмидийн Даложав	- Хан-Уул дүүрэг		
145. Дүүдэнгийн Мядаг	- Хан-Уул дүүрэг		
146. Дунгийн Очир	- Хан-Уул дүүрэг		
147. Цагаандайн Рааш	- Хан-Уул дүүрэг		
148. Сэнгэдоржийн Рэндоо	- Хан-Уул дүүрэг		

### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Абдолдагийн Хабдарал	- Баян-Өлгий аймаг
2. Сүрэнгийн Доржжав	- Говь-Алтай аймаг
3. Хайнзангийн Жийжав	- Говь-Алтай аймаг
4. Вандандоогийн Дамдинжав	- Говьсүмбэр аймаг
5. Түмэнжаргалын Цэмбээ	- Дархан-Уул аймаг
6. Жамбын Рэнцэнхорлоо	- Орхон аймаг
7. Шаравын Цэрэнжав	- Сүхбаатар аймаг
8. Гэнзгийн Дуглаа	- Увс аймаг
9. Баржавын Нямбуу	- Ховд аймаг
10. Ихрагийн Схах	- Ховд аймаг
11. Насангийн Балдан-Ёндон	- Хэнтий аймаг
12. Түмэнгийн Дагва	- Хэнтий аймаг
13. Лувсангийн Цэндгомбо	- Хэнтий аймаг
14. Шаравын Чойдог	- Хэнтий аймаг
15. Жамцын Чойжил	- Хэнтий аймаг
16. Дамдинсүрэнгийн Баасанжав	- Хан-Уул дүүрэг

### — МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ —

2000 оны 8 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

### Зарим багш нарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Их, дээд сургуульд олон жил үр бүтээлтэй багшилж, сурах бичиг, эрдэм шинжилгээний олон бүтээл туурвиж, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, залуу үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан багш нарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

1. Дэндэвийн Гончиг -Хөдөө аж ахуйн их сургуулийн мал үржүүлэг, генетикийн

тэнхмийн зөвлөх багш

2. Цэдэвийн Өнөрбаян - Улсын багшийн их сургуулийн монгол хэл, уран зохиолын факультетийн декан

3. Лодойн Шагдар - Анагаах ухааны их сургуулийн чих, хамар хоолой судлалын тэнхмийн багш

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИ

Н. БАГАБАНДИ





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 8 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

### Дамбийн Оюунцэцэгт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, сургалтад дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэн, сурагчдад гүн бат мэдлэг олгох, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төв аймгийн Зуунмод сумын "Хүмүүн" цогцолбор дунд

сургуулийн бага ангийн багш Дамбийн Оюунцэцэгт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

### "ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ" МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

"Өршөөл үзүүлэх тухай" 2000 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Монгол Улсын хуулийн зарим заалтыг нэг мөр нэгдмэлээр ойлгож, зөв хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. "Өршөөл үзүүлэх тухай" энэхүү хууль 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 09 цагаас өмнө гэмт хэрэг үйлдсэн хүмүүст болон 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 09 цагаас өмнө гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүмүүст хамаарна.

2. "Өршөөл үзүүлэх тухай" энэ хуулийн зарим заалтыг дараахи байдлаар ойлгож хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

а. Энэ хуулийн 1.1,1.2,1.3,1.4, 1.5-д дурьдсан өршөөл үзүүлэх үндэслэл, нөхцлийг шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол /шийдвэр/ эсхүл төрсний гэрчилгээ, иргэний паспорт, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бусад баримт бичиг, "арван зургаан насанд хүрээгүй", арван дөрвөн насанд хүрээгүй гурав ба түүнээс дээш хүүхэдтэй буюу гурав хүртэл насны хүүхэдтэй болон жирэмсэн", "өөрийн асрамжинд байгаа арван зургаа хүртэлх насны хагас өнчин хүүхэдтэй хүмүүс буюу өрх толгойлсон эмэгтэй" болох нь баг, сум, хороо, дүүргийн Засаг даргын тодорхойлолт, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, аль нэг нь нас барсан, нас барсанд тооцогдсон, сураггүй алга болсон тухай хууль ёсны баримт, "жирэмсэн", буюу тахир дутуугийн нэг, хоёрдугаар зэрэгт орсон нь мэргэжлийн эмнэлгийн комиссын акт, дүгнэлт зэрэг албан ёсны баримтаар хөдөлбөргүй тогтоогдсон байвал зохино.

Энэ хуульд дурьдсан өршөөл үзүүлэх үндэслэл, нөхцлүүд нь 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 09 цагаас өмнө буй болсон байна.

3. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд дурьдсан "энх удаа хорих ял шийтгүүлсэн" гэдэгт урьд хорих ял шийтгүүлж байгаагүйгээс гадна хорихоос өөр төрлийн ял шийтгүүлж байсан, урьд хорих ял шийтгүүлж байсан боловч Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлд зааснаар ял шийтгэлгүй болсон болон ял шийтгэлгүйд тооцогдсон, хорих ял нь тэнсэгдэж хянан халгалзсан, хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдээгүй, уг хугацаа дууссан, түүнчлэн Эрүүгийн хуульд заасан хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн боловч нэг таслан шийдвэрлэх

тогтоолоор анх удаа хэд хэдэн зүйлээр ял шийтгүүлсэн болон шийтгүүлж байгаа этгээдийг хамааруулан ойлгоно.

4. Гэм буруутай этгээд 16 насанд хүрээгүй байхдаа 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдрөөс өмнө болон дараа нь Эрүүгийн хуульд заасан өөр өөр төрлийн хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 09 цагаас өмнө үйлдсэн /энэ хуулиар хориглоогүй/ хэрэгт оногдуулсан ялд зохих өршөөл үзүүлж, харин 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 09 цагаас хойш үйлдсэн хэрэгт оногдуулсан ялд энэ хуульд заасан өршөөл үл хамаарна.

Түүнчлэн гэм буруутай этгээд 16 насанд хүрээгүй байхдаа 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 09 цагаас өмнө болон дараа нь Эрүүгийн хуульд заасан нэг төрлийн хэргийг үргэлжилсэн болон давтан үйлдлээр үйлдсэн бол энэ хуульд заасан өршөөлд хамаарахгүй.

5. Энэ хуулийн 1.2,1.3, 1.4-д дурьдсан "хүмүүс" гэдэгт арван дөрвөн насанд хүрээгүй гурав ба түүнээс дээш хүүхэдтэй, мөн өөрийн нь шууд асрамжинд хууль ёсоор байгаа 16 хүртэлх насны хагас өнчин хүүхэдтэй болон тахир дутуугийн нэг, хоёрдугаар зэрэг /групп/-т орсон нь 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 09 цагаас өмнө тогтоогдсон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь хамаарна.

6. Энэ хуулийн 1.3 дахь хэсгийн "өөрийн шууд асрамжинд байгаа арван зургаа хүртэл насны хагас өнчин хүүхэдтэй хүмүүс буюу өрх толгойлсон эмэгтэйчүүд" гэдэгт уг өнчин хүүхдийн төрсөн болон үрчилж авсан эцэг, эх асран хамгаалах үүргийг зохих журмын дагуу хүлээсэн этгээд хамаарах бөгөөд "Өрх толгойлсон эмэгтэй" гэдэг заалт нөхөргүй, нөхөр нь нас барсан, эсхүл нас барсанд тооцогдсон, сураггүй алга болсон болон нөхрөөс гэрлэлтээ албан ёсоор цуцлуулсан зэрэг нь ёсоор нотлогдсон эмэгтэйд хамаарна.

7. Энэ хуулийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт дурьдсан "... насанд хүрээгүй" гэдэг нь уг этгээд 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 09 цагт дээр дурьдсан насанд хүрээгүй байхыг ойлгоно.

8. Энэ хуульд заасан өршөөл үзүүлэх ажиллагааг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын хяналтын шатанд гүйцэтгэхгүй боловч өршөөл үзүүлэх буюу үл үзүүлэх үндэслэл, нөхцлийг заавал шалган тогтоосон байвал зохино. Шүүх эрүүгийн хэргийг өрдийн



журмаар хянан хэлэлцэж шүүгдэгчийг гэм буруутай гэж үзвэл таслан шийдвэрлэх тогтоолоор Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэгт заасан ял шийтгэл оногдуулах асуудлыг шийдвэрлэж ялын төрөл, хэмжээ, эдлүүлэх хэлбэрийг тогтоосны дараа энэ хуулийг хэрэглэх эсэхийг мөн хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн шийдвэрлэнэ.

9. Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж шийтгүүлж байгаа болон хэд хэдэн таслан шийдвэрлэх тогтоолоор ял оногдуулж байгаа тохиолдолд шүүгдэгчид энэ хуульд заасан өршөөл үзүүлэхдээ зүйл, хэсэг тус бүрээр оногдуулсан ялд тохирох өршөөлийг үзүүлсний дараа үлдсэн ялын хөнгөнийг хүндэд багтаах, эсхүл бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэх зэргээр Эрүүгийн хуулийн 37, 38 дугаар зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

10. Ял эдэлж байгаа этгээдэд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан өршөөл үзүүлэхдээ энэ тогтоолын 9 дүгээр зүйлд заасан журмаар гүйцэтгэх бөгөөд хэрэв хэд хэдэн гэмт хэрэгт ял шийтгүүлж хөнгөн ялуудыг хүнд ялд нь багтаасан бөгөөд багтаасан ял нь өршөөлд үл хамаарах бол өршөөлд хамаарах зүйл, хэсгээр оногдуулсан ялд зохих өршөөлийг үзүүлнэ. Мөн хэд хэдэн таслан шийдвэрлэх тогтоолоор ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 38 дугаар зүйлийг журамлан нэмж нэгтгэсэн тохиолдолд өршөөлд хамаарах зүйл, хэсэг бүрээр оногдуулсан ялд өршөөл үзүүлж хорих ял биеэр эдэлсэн хугацааных нь дотор өршөөлд үл хамаарах зүйл, хэсгээр эдэлсэн ялын хэмжээг нь хувь тэнцүүлэн бодож хасаж, өршөөлд үл хамаарах ялын үлдэх хэсгийг эдлүүлэхээр тогтооно. Хэрэв нэмж нэгтгэсэн ял нь тус бүрдээ өршөөлд хамаарагдаж байгаа бол уг этгээдэд зохих өршөөлийг үзүүлнэ.

11. Энэ хуулийн 2 дугаар зүйлд дурьдсан "Хорихоос өөр төрлийн хөнгөн ялаас хэлтрүүлэх" өршөөлийг уг ялыг эдлүүлж байгаа газрыг харьяалах шүүхийн шүүгч ЭБШ хуулийн 360 дугаар зүйлд заасан журмаар захирамж гарган шийдвэрлэнэ.

12. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан өршөөлийг үзүүлэхэд шүүхээс ямар нэгэн шийдвэр гаргах шаардлагагүй бөгөөд Цагдаагийн байгууллага энэ хуулийн заалтыг баримтлан ялтны хувийн хэргэ Иргэний бүртгэл мэдээллийн төвд байгаа ял шийтгэлийн тухай тэмдэглэл /бүртгэл/-д өршөөл үзүүлсэн тухай зохих тэмдэглэл хийнэ.

13. Энэ хуулийн 5.2 дахь хэсгийн "гурав ба түүнээс дээш удаа ял шийтгүүлсэн" гэдэгт уг этгээд Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлд заасан ял шийтгэлгүй болох хугацаа өнгөрөөгүй байхад хорих болон өөр төрлийн ялын аль алианаар гурав буюу түүнээс дээш удаа ял шийтгүүлсэн явдал хамаарна.

14. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5-д заасан хүмүүст энэ хуульд заасан аль ч өршөөл үл хамаарна.

15. Энэ хуулийн 3 дугаар зүйлд . . . "гурваас арван жил", "арван нэгээс арван таван жил", "арван зургаагаас хорин таван жил" гэсэн хугацаа тогтоосон бөгөөд арваас арван нэгэн жил хүртэлх, арван таваас арван зургаан жил хүртэлх хоорондын хугацаа орхигдсон байх тул арваас арван нэгэн жил хүртэлх, арван таваас арван зургаан жил хүртэлх хугацааг урагш нь "арав", "арван тав" гэсэн хугацаанд оруулан тооцвол зохино.

Тухайлбал:

"10 жил 6 сарын" хорих ялыг арван жилд,

"арван таван жил 11 сар 29 хоногийн" хорих ялыг арван таван жилд хамааруулна.

16. Өршөөлийн хуулийг шүүх буруу хэрэглэсэн тохиолдолд Дээд шатны шүүх уг хэргийг давж заалдах буюу хяналтын журмаар хянан хэлэлцэхдээ алдаа, зөрчлийг залруулан зөвтгөж байвал зохино.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ч.ГАНБАТ

ШҮҮГЧ

ДАЛТАНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 303

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх зорилгоор Монгол Улсын дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, мөн хуулийн 21 дүгээр зүйлд заасан " . . . Улсын Их Хуралд суудал бүхий нам" гэдгийг Улсын Их Хурлын ээлжит болон нөхөн сонгуулиар нам дангаараа буюу намуудын эвслээс тодорхой иргэнийг нэр дэвшүүлж, тэр нь Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон

бөгөөд тухайн намын гишүүнчлэлийг хадгалж байгаа буюу гишүүн бус этгээд нэр дэвшсэн намаасаа өөр намд элсээгүй тохиолдолд санал хураах хуудсанд нэр дэвшигчийн /гишүүний/ нэрийг дэвшүүлж бичигдсэн намыг ойлговол зохино.

1. Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуульд заасан "Улсын Их Хуралд суудал бүхий нам" гэсэн ойлголтыг тухайн хуульд өөрөөр заагаагүй бол энэ тайлбарын адилаар ойлгож байхаар тогтоосугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ ШҮҮГЧ

Ч.ГАНБАТ Д.ТУНГАЛАГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487